



АРВАЙХЭЭР СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 296

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030573

## Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / .... хуудас/-ийг хавсаргав. .

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН



## 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД АРВАЙХЭЭР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### 1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ - АЖИЛ ОРЛОГОТОЙ ИРГЭН

1.1. Хүнсний ногоо даршлах, савлах үйлдвэрүүдийг орчин үеийн техник технологид суурилан бий болгож, өрх, иргэдийг ажлын байраар хангана.

1.2. Мал аж ахуйн түүхий эдэд түшиглэсэн арьс, шир боловсруулах үйлдвэрүүд байгуулна.

1.3. Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй нэгжүүдийг дэмжих, мах дайвар бүтээгдэхүүний үйлдвэр, хөргүүртэй тээврийн үйлчилгээг бий болгож, махны экспортоос орох орлогыг нэмэгдүүлнэ.

1.4. Сүү, сүүн бүтээгдэхүүний томоохон үйлдвэрийг байгуулах, үйл ажиллагаа явуулж байгаа цех, өрхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

1.5. Ажлын байр нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч, 3 мянгаас доошгүй ажлын байр бий болгох, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 2 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй болгоно.

1.6. Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.7. Арвайхээр хотын барилгын материал үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлнэ.

1.8. “Нэг өрх – Нэг ажлын байр” хөтөлбөр, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллана.

1.9. Шинээр ажлын байр олноор бий болгосон, тогтвортой үйл ажиллагаа явуулж, ажлын байраа хадгалан сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих бодлого баримтлана.

1.10. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх, ажилд зуучлах үйлчилгээнд хөдөлмөр эрхлээгүй иргэд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчид зэрэг 3000-аас доошгүй иргэнийг хамруулна.

1.11. Хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэргэжилтэй ажилтанг мэргэжлийн болон давтан сургалтаар 1000-аас доошгүй ажилгүй иргэдийг бэлтгэж, бизнес эрхлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд нь зориулж хүү багатай, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

1.12. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн өрхүүдийг оновчтой тодорхойлж, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээг чанаржуулна.

1.13. Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахад орон нутгийн аж ахуй, нэгжүүдийг давуу эрхтэй оролцуулна.

## 2. ХОТ БАЙГУУЛАЛТ - ХӨГЖЛИЙН ГАРЦ

- 2.1. Гэр хорооллын ундны усан санг төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэх, ус түгээх байрны нөхцлийг сайжруулж, ухаалаг худгийн системд бүрэн шилжүүлнэ.
- 2.2. Гэр хорооллын айл өрхүүдийг инженерийн шугам сүлжээнд холбох нөхцлийг бүрдүүлэх, ариун цэврийн байгууламжийг сайжруулах “Эко 0” төслийг хэрэгжүүлнэ.
- 2.3. Хотын нийтийн тээврийн үйлчилгээний маршрутыг өргөтгөх, орчин үеийн стандартад нийцсэн автобусны зогсоолын тоог нэмэгдүүлж, парк шинэчлэлийг үе шаттайгаар хийнэ.
- 2.4. Хуучин орон сууцнуудыг дахин төлөвлөлтөд оруулж барилгын гадна фасад, дээвэр засвар, инженерийн шугам сүлжээний шинэчлэл, орчны тохижилтын ажлыг хийнэ.
- 2.5. Хотын шинэ суурьшлийн бүсийн цахилгаан эрчим хүчны өргөтгөл хийж, дэд станц, агаарын шугам татах, айл өрхүүдэд цагийн ялгавартай тоолуурын хэрэглээг нэвтрүүлнэ.
- 2.6. Авто болон явган хүний зам, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн засвар арчлалтыг тогтмол хийж, авто замын уулзваруудад гэрлэн дохио нэмэгдүүлнэ.
- 2.7. Шинэ суурьшлийн бүсэд баригдаж буй хаус хороолол, төрийн байгууллагуудыг авто замтай холбох, авто зогсоолыг шийдвэрлэж, орчны тохижилтыг хийнэ.
- 2.8. Төв захыг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэх, стандартын тоног төхөөрөмж бүхий худалдааны төв байгуулна.
- 2.9. “Хашаандаа сайхан амьдаръя” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.10. Сууц өмчлөгчдийн холбооны /СӨХ/ үйл ажиллагааг тогтмолжуулж дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 2.11. Ахмадын болон залуусын түрээсийн орон сууцны төслийг хэрэгжүүлнэ.
- 2.12. Арвайхээр хотын автозамын сүлжээг өргөтгөнө.

## 3. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ- ЭРҮҮЛ ХҮНС

- 3.1. Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээг дэмжин, үйлчилгээний чанарыг сайжруулах замаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван байдлаа хадгална.
- 3.2. Фермүүдийг хөгжүүлэхтэй холбогдуулан тэжээл үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөнгөвчлөхөд чиглэсэн бага оврын техник технологи нэвтрүүлэх, өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех байгуулахад дэмжлэг үзүүлнэ.



3.3. Мах, сүүний үйлдвэрийн үйл ажиллагааг эрчимжүүлж, өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн болон туслах аж ахуй байгуулах санал санаачилгыг дэмжнэ.

3.4. Хотын төвийн А зэрэглэлийн бүсэд мал болон туслах аж ахуй эрхлэж буй иргэдийг тусгай бүсэд шилжүүлэн хүн амыг эрүүл, аюулгүй орчин амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

3.5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн нөхөрлөл, хоршоо байгуулах санал санаачлагыг дэмжин бүтээгдэхүүн борлуулах, зуучлах үйлчилгээг үзүүлж, ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлж, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод давтан сургах, туршлага судлуулах ажлыг хэрэгжүүлнэ.

3.6. Газар тариалангийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, технологи нэвтрүүлж, Дайргын голын хойд хэсгийн услалтын систем, үерийн далан байгуулж органик бордооны цех, хүнсний ногооны төрөлжсөн зоорь /энгийн болон автомажсан, механикжсан/ байгуулна.

3.7. Арвайхээр хотын дулааны станцыг түшиглэн өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэн хүнсний болон эмчилгээний ач холбогдол бүхий ховор ургамал, эрт ургацын хүнсний ногооны тариалалтыг хөгжүүлнэ.

3.8. Малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг баримтлах, малын чанарыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх

3.9. Бэлчээрийн болон эрчимжсэн аж ахуйг нийгмийн хөгжлийн чиг хандлага, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлж өндөр ашиг шимт үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх

#### **4. БАЙГАЛЬ ОРЧИН - НОГООН ХОТ**

4.1. Хатуу хучилттай авто зам дагуу ногоон зурвас байгуулах, айл өрхийн эдэлбэр газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар хотын ногоон байгууламжийг 30 га нэмэгдүүлнэ.

4.2. Мод үржүүлгийн газар болон өвлийн хүлэмж байгуулна.

4.3. Хог хаягдлын менежментийг сайжруулж, хог ангилан ялгах үйл ажиллагааг аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд хэвшүүлэх, хогийн цэгийн орчныг тохижуулан техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

4.4. Усны нөөц нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, Дайргын гол, Дэлгэрэх гол, Ногоон зүлгийн эхийг хамгаалах нөхөн сэргээж тохижуулна.

4.5. Агаарын бохирдлыг бууруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан түлшээр хангах, төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг хэрэгжүүлнэ.

4.6. Нийтийн эзэмшлийн соёл амралтын хүрээлэн, ногоон бүсүүдэд орчин үеийн стандартад нийцсэн нийтийн бие засах газрыг нэмэгдүүлнэ.



## 5. НИЙГМИЙН БОДЛОГО - ХҮНИЙ ХӨГЖИЛ

### 5.1. Эрүүл мэндийн үйлчилгээ: Эрүүл иргэн – Нийгмийн хөгжилд

5.1.1. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ӨЭМТөв, багийн Засаг даргын хамтын ажиллагааг сайжруулж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

5.1.2 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангана.

5.1.3 Халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгоно.

5.1.4 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг төрөөс бодлогоор дэмжиж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулна.

5.1.5 Иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг тогтмолжуулж, онош тодруулах шаардлагатай иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулна.

### 5.2.Боловсролын үйлчилгээ: Чанартай боловсрол – Чадварлаг багш

5.2.1 ЕБСургууль, СӨББайгууллагын анги дүүргэлтийн коэффициентийг тэнцвэржүүлж, шаардлагатай сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх, засварлах замаар материаллаг баазыг нэмэгдүүлнэ.

5.2.2 Төрөлжсөн кабинет, багш хөгжлийн төв, биеийн тамирын зал, тоглоомын талбайн орчин нөхцлийг сайжруулж, багш, суралцагчдын хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.

5.2.3 Хувийн хэвшлийн цэцэрлэг, яслийн үйл ажиллагааг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжсэн шинэ цэцэрлэг барьна.

5.2.4 Багшийн ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, хөдөлмөрийн үнэлэмж, орон байрны нөхцлийг сайжруулан багш нарын арга зүйн хөгжлийг дэмжиж, тэргүүн туршлага, ур чадвараа түгээн дэлгэрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

5.2.5 Иргэдийг насан туршийн боловсрол эзэмших, амьдрах, аж төрөх ухаанд суралцуулах чиглэлээр бие даасан төвийн үйл ажиллагааг дэмжиж, сургуулиас гадуурх сургалтын байгууллагаар дамжуулан хүүхэд, залуучууд насанд хүрэгчдийг тохиромжтой хэлбэрээр суралцах хүрээг өргөжүүлэх, ном сурах бичгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.2.6. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг хүүхдийн дасгал хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх хэрэглэгдэхүүн, багажаар хангаж хүүхдийн тулгуур эрхтний хөгжлийг сайжруулна.

### **5.3 Соёл, урлаг, аялал жуулчлал, спорт, нийтийн биеийн тамир: Иргэний хөгжил-Идэвхтэй амьдрал**

5.3.1 Соёлын биет болон биет бус өвийг сурталчлах, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад төр, иргэн, олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлнэ.

5.3.2 Нийтийн биеийн тамирыг иргэд, гэр бүл, хамт олны санаачлагад тулгуурлан өрнүүлэх

5.3.3 Арвайхээр сумын аялал жуулчлалын бодлого төлөвлөлтийг бий болгож, аялал жуулчлалыг хөгжүүлэх

5.3.4 Соёл урлагийн мэргэжлийн байгууллага, сургууль, цэцэрлэгийн соёлын үйл ажиллагааг дэмжих.

5.3.5. Арвайхээр лигийн тэмцээнийг тогтмолжуулж, цар хүрээг тэлнэ.

5.3.6. Тив, дэлхий, улсын хэмжээний уралдаанд ардын урлаг, сонгодог урлагийг дэмжин оролцуулж хөгжүүлнэ.

### **5.4 Хүүхэд, залуучууд гэр бүлийн хөгжил: Гэр бүлийн төлөвшил - Хүүхдийн ирээдүй**

5.4.1 Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгэм, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны түншлэлийг бэхжүүлж, төсөл, хөтөлбөр болон үйл ажиллагааг дэмжнэ.

5.4.2 Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, амьдралын зөв дадалд сургах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, мэргэжлийн чиг баримжаатай болгох төрөл бүрийн секц, дугуйлан, сургалт, мэдээллийн олон талт үйл ажиллагааг дэмжнэ.

5.4.3 Хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үнэлгээ хийсэн мэдээллийн санд тулгуурлаж нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэх

## **6. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ - ИРГЭН ТАНД**

6.1. Багийн иргэдийн Нийтийн хурлын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж залуучуудын идэвх, оролцоог нэмэгдүүлнэ.

6.2. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөж, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ.

6.3. Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болгоход чиглэсэн шинэ дэвшилтэт хэлбэрийн үйлчилгээг тууштай нэвтрүүлж, төрийн албаны хяналтын сүлжээг бий болгоно.

6.4. Иргэд, олон нийтийн оролцоотойгоор газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг нээлттэй ил тод хэрэгжүүлнэ.



6.5. Иргэд, хувийн хэвшил, аж ахуйн нэгжид хийх төрийн хяналт шалгалтыг багасгаж зөвлөн туслах үйлчилгээг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагыг чадавхжуулна.

6.6. Хүний эрх, үүргийн нэгдлийг хангах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарч, эрх зүйн туслалцааны бие даасан үйлчилгээг бий болгоно.

6.7. Орон нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагуудаас хүний эрх, эрх чөлөө, иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахын өмнө иргэд, хуулийн этгээд, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулсан нийтийн сонголт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, тэдгээрээс гарсан саналуудыг тухайн гарах шийдвэрт тусгаж, эргэн мэдээлэх асуудлыг журамлаж хэрэгжүүлнэ.

6.8. Гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан болсон архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, амьдралын буруу зуршил зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, монгол ёс заншлаа дээдлэх ухамсрыг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэн зөв хүмүүжил олгох ажлыг иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

6.9. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, орон байрны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хангах чиглэлээр үйл ажиллагааг явуулж байгаа олон нийтийн зөвлөл, хөршийн холбоо, хэсгийн ахлагч, нөхөрлөл, бүлгэмийн үйл ажиллагааг бүх талаар дэмжин ажиллана.

6.10. Гудамж, нийтийн эзэмшлийн зам талбай, захын хорооллуудад үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх, таслан зогсоох зорилгоор Арвайхээр сумын камерын хяналтын систем, гэрэлтүүлгийн тоо, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

6.11. Халуун ус, ахуйн үйлчилгээг гэр хорооллын айл өрхүүдэд ойр хүртээмжтэй байлгахад анхаарч үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжнэ.

АРВАЙХЭЭР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

